



# “ЦЕМЕНТ ШОХОЙ” ХК



## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 ОН

**АЛСЫН ХАРАА:** Монголын цемент шохойн тэргүүлэгч  
үйлдвэрлэгч, экспортлогч байна

**ЭРХЭМ ЗОРИЛГО:** "Чанартай бүтээгдэхүүнээр хэрэглэгчийн  
эрэлт хэрэгцээг хангагч, оролцогч  
талуудынхаа ашиг сонирхлыг дээдлэгч,  
нийгмийн хариуцлагыг эрхэмлэгч  
компани байна"

**ҮНЭТ ЗҮЙЛС:**

- Уламжлал, эв нэгдлийн бахархал
- Чанар
- Байнгын хөгжил дэвшил
- Тогтвортой, үр ашигтай хамтын ажиллагаа





## ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

"Цемент Шохой" ХК-ийн хамт олон 2020 онд 400.0 мянган тонн цемент, 55.0 мянган тонн шохой үйлдвэрлэж, үйлдвэрлэлийн өртөг зардлыг бууруулах, тасралтгүй хэвийн жигд ажиллагааг хангах, хэрэглэгчдэдээ чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөт зорилт тавин ажилласнаас 377.6 мянган тонн цемент, 360.4 мянган тонн чулуунцар, 44.9 мянган тонн шохой үйлдвэрлэлээ.

Тус компани нь үндсэн үйлдвэрлэлийн зэрэгцээ ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, сүм орон нутгийн хэмжээнд залуу үе, ахмадуудад зориулсан арга хэмжээ, үүлзалт, уралдаан тэмцээн, бүтээн байгуулалтын ажлууд хийж, хэрэгжүүлж ажилласан.

Цаашид компанийн зүгээс

- Шохойн үйлдвэрийн шинэчлэлт
- Дулааны станцын шинэ эх үүсвэр
- Цементийн үйлдвэрлэлийг бүрэн хүчин чадалд хүргэж жилдээ 1,0 сая тонн цемент үйлдвэрлэн борлуулах зорилт тавин ажиллаж байна.

Монгол улсын бүтээн байгуулалтад үеийн үед жинтэй хувь нэмэр оруулж ирсэн Барилгын салбар, Барилгын материал үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчид болон үе үеийн ахмадууд, бидэнтэй хамтран ажилладаг хувь хүн, аж ахуйн нэгж, хамт олондоо болон нийт хэрэглэгчдэдээ Хөгжил дэвшилд хөтөлсөн 38 жилийн хугацаанд бидэнтэй хамт байсан та бүхэндээ сайн сайхныг хүсье.

"ЦЕМЕНТ ШОХОЙ" ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
АСАРВААНИЙН ШООВДОР





## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Алтан гадас” одонт Хөтөлийн “Цемент Шохой” ХК нь 1983 онд “Цемент шохойн комбинат” нэртэйгээр үүсгэн байгуулагджээ. Тус үйлдвэр нь анх ЗСБНХУ-ын зураг төслийн дагуу тус улсын техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, жилд 500 мянган тонн цемент, 65 мянган тонн шохой, 162 мянган Гкал дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай иж бүрэн үйлдвэрийн цогцолбороор байгуулагдсан ба үйлдвэрийг дагасан хот сүндэрлэн боссон юм.

2011 оноос эхлэн үндэсний хөрөнгө оруулагч “Хөтөл” ХХК-ийн санхүүжилтээр дэлхийн шилдэг технологи, хуурай аргаар жилд 1 сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг бүтээн байгуулж, 2014 онд ашиглалтад оруулан амжилттай ажиллаж байна.

Хөтөлийн “Цемент Шохой” ХК нь 2015 онд хувьчлагдсан, 2020 оны байдлаар нийт 735 ажилтантай, мэргэжлийн 11 хэлтэс, 9 цех, албатайгаар үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа явуулж байгаа ба олон жилийн турш цемент, шохой, дулаан үйлдвэрлэх үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд явуулж ирсэн туршлагатай хамт олон юм.

Тус компанийн Монгол Улсын хөгжил дэвшил, бүтээн байгуулалтад оруулж буй хувь нэмрийг өндрөөр үнэлж, төрийн дээд шагнал “АЛТАН ГАДАС” одон, үндэсний бүтээн байгуулалтын дээд шагнал “ТӨРИЙН ГЭРЭГЭ”, аж үйлдвэрийн салбарын “ТЭРГҮҮН ДЭЭД” шагналуудыг тус тус хүртээсэн байна.

## ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДЛУУД



1983 → Шохойн 1-р зуухыг анх ашиглалтанд оруулав.



1986 → Цементийн үйлдвэрийн технологийн 1, 2-р шугамыг улсын комисс хүлээн авлаа.



2006 → Тус үйлдвэрийн анхны дарга, Зөвлөх инженер Ц.Сампилноров "Монгол Улсын Гавьяат барилгачин" цол хүртлээ. 2006 оны "TOP-100 аж ахуйн нэгж" батламжаар шагнуулав.



2008 → Олон жил ашиглалтгүй байсан цемент үйлдвэрлэлийн эргэх 1-р зуухыг өөрсдийн инженер техникийн ажилчдын хүчээр их засвар хийж ажиллуулав.



1984 → Цементийн үйлдвэрийн 1-р зуухыг галлав. Шохой үйлдвэр анхны бүтээгдэхүүнээ Эрдэнэтийн УБҮ-т нийлүүлж эхлэв.



1987 → Эргэх зуухны түүхий эв болон цементийн тээрмүүдийн төслийн хүчин чадлыг бүрэн ашиглаж, 1 сая дахь тонн цемент үйлдвэрлэв.



2007 → 3 сая дахь тонн цементийг үйлдвэрлэв. М400 маркийн цемент Монгол улсын "Үндэсний шилдэг 99 бүтээгдэхүүн-Үлэмжийн чанарын батламж" хүртлээ.



2009 → Ерөнхий технологийн Т.Цоодол "Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан" цол хүртсэн.



## ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДЛУУД



Хуурай технологийн үйлдвэрийн шав тавих ёслол болов.

2011



Хуурай технологийн шинэ үйлдвэрийн туршилт, тохируулгын ажил эхэлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 132 дугаар зарлигаар Хөтөл "Цемент-Шохой" ХК-ийг "Алтан гадас" шаангаар шагнав.

2013



Үнэвэрийн бүтээн байгуулалтын дээд шагнал "Төрийн Гэрээ" шагнал хүртэв.

2015



"Цемент-Шохой" ХК-ийн Гүйцэтгэх захирал А.Шоовдор "Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан" цол хүртсэн.

2018



4 сая дахь тонн цементээ үйлдвэрлэв.

2012



Хуурай технологийн шинэ цементийн үйлдвэрийн нээлийн ажиллагаа болж, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг оролцож албан даалгавар өгөв.

2014



"Цемент-Шохой" ХК-ийн түүхэн хугацаанда 5 сая дахь тонн цемент үйлдвэрлэн гаргалаа.

2016



Топ 100 аж ахуй нэгжээр шалгарсан.

2019



Компанийн дэргэдэх "Сургалтын төв"-ийн үйл ажиллагааг эрхлэх албан ёсны зөвшөөрлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас авснаар 9 төрлөөр мэргэжлийн үр чадвартай, мэргэжилтэй ажилтныг дотооддоо бэлтгэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

2019



## БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТҮХАЙ

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА: Цемент, шохойн үйлдвэрлэл

ТҮСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА: Дулааны эрчим хүч үйлдвэрлэл, бусад

Үйлдвэр ашиглалтад орсноос хойш нийт 6,8 сая тонн ЦЕМЕНТ үйлдвэрлэж барилгын салбарт, үүний дотор тусгай зориулалтын өндөр ангиллын цементийг төмөр бетон дэрний үйлдвэрт, 1,5 сая тонн ШОХОЙ үйлдвэрлэж Үүлын баяжуулах Эрдэнэт үйлдвэр болон төмөрлөгийн үйлдвэрлэлийн технологи, өнгөт металлын баяжуулалт, барилгын материалын үйлдвэрлэлд, 2,9 сая Гкал ДУЛААН үйлдвэрлэж, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Хөтөл тосгоны төр, төсвийн байгууллагууд, аж ахуйн нэгж, оршин суугчдыг дулааны эрчим хүчээр ханган, нийлүүлж ирсэн.

Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага ISO/IEC17025 стандартаар итгэмжлэгдсэн лабораторийн хяналтанд цемент, шохойн түлш түүхий эд, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүдэд стандартын дагуу бүрэн цогц шинжилгээ хийж, MNS974:2008 стандартыг бүрэн хангасан, EN197 олон улсын стандартад нийцсэн портландцемент, MNS347:2002 стандартын шаардлага хангасан шохой үйлдвэрлэж байна.





## БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТҮХАЙ



1. Портланд MNS974:2008, EN197  
PC 42,5 - Ердийн портланд цемент  
OPC 42,5-15% - Эрдэс идэвхт нэмэлттэй портланд цемент  
PC 52,5 - Өндөр ангиллын портланд цемент



2. Шохой MNS347:2002  
80%-иас дээш идэвхжилтэй, 0-120 мм  
ширхэглэлтэй  
барилгын болон технологийн хэрэглээний  
шохой



3. Чулуунцар - Хагас боловсруулсан  
бүтээгдэхүүн /клинкер/







## ҮЙЛДВЭРЛЭЛТ БОРЛУУЛАЛТ

ЦЕМЕНТ ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ /тонн/



ШОХОЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ /тонн/



## САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ХӨРӨНГӨ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	7,681,304.5	163,574,868.2
1.1.2	Дансны авлага	32,416,705,707.3	18,543,729,269.9
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	661,049,163.9	733,359,753.9
1.1.4	Бусад авлага	0.0	628.5
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.0	0.0
1.1.6	Бараа материал	12,747,470,931.1	15,899,503,861.9
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	658,482,597.9	786,076,757.2
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.0	0.0
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	410,682,448.2	546,192,946.0
1.1.20	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>46,902,072,152.9</b>	<b>36,672,438,085.6</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	255,716,376,362.0	246,260,829,031.0
1.2.2	Биет бус хөрөнгө	5,599,364,256.4	5,526,360,693.7
1.2.3	Биологийн хөрөнгө	0.0	0.0
1.2.4	Дуусаагүй барилга	5,000,000.0	5,000,000.0
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.0	0.0
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.0	605,818,953.7
1.2.7	Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	281,043,143.4	274,554,984.6
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.0
1.2.20	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>261,601,783,761.9</b>	<b>252,672,563,663.0</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>308,503,855,914.8</b>	<b>289,345,001,748.5</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
2.1.1.1	Дансны өглөг	13,372,214,513.6	7,270,186,583.3
2.1.1.2	Цалингийн өглөг	407,985,029.0	356,984,690.0
2.1.1.3	Татварын өр	15,675,855,953.4	17,350,003,297.7
2.1.1.4	НДШ-ийн өглөг	5,931,341,299.1	4,514,877,860.3
2.1.1.5	Богино хугацаат зээл	1,578,405,835.2	1,392,666,394.6
2.1.1.6	Хүүний өглөг	9,434,462,214.2	12,182,337,241.1
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.0	0.0
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	10,896,954,052.7	4,164,903,764.1
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	172,800.0	152,849,075.0
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.0	0.0
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус	0.0	0.0
2.1.1.20	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>57,297,391,697.2</b>	<b>47,384,808,906.2</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	43,416,835,529.6	43,416,835,529.6
2.1.2.2	Нөөц / өр төлбөр /	712,714,526.9	1,008,187,319.0
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.0	0.0
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	2,155,019,122.5	2,198,495,809.0
2.1.2.20	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>46,284,569,179.0</b>	<b>46,623,518,657.5</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>103,581,960,876.2</b>	<b>94,008,327,563.7</b>
2.3	<b>Эздийн өмч</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
2.3.1	Төрийн өмч	0.0	0.0
2.3.2	Хувийн өмч	0.0	0.0
2.3.3	Хувьцаа	287,684,089,300.0	287,684,089,300.0
2.3.4	Халаасны хувьцаа	0.0	0.0
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	420,000,000.0	420,000,000.0
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	41,284,046,791.0	41,284,046,791.0
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.0	0.0
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,905,957,879.0	2,511,776,832.7
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-126,372,198,931.3	-136,563,238,738.8
2.3.20	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>204,921,895,038.7</b>	<b>195,336,674,184.9</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>308,503,855,914.8</b>	<b>289,345,001,748.5</b>



## ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайланг үеийн дүн	Өссөн дүн
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>65,125,456,169.2</b>	<b>71,825,200,077.3</b>
2	Борлуулалтын өртөг	56,284,484,550.6	53,868,435,232.7
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>8,840,971,618.6</b>	<b>17,956,764,844.6</b>
4	Түрээсийн орлого	15,186,890.7	41,727,272.6
5	Хүүгийн орлого	0.0	0.0
6	Ногдол ашгийн орлого	0.0	0.0
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.0	0.0
8	Бусад орлого	1,016,631,850.7	1,423,192,583.2
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,824,035,985.6	2,070,847,130.2
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,405,143,140.4	1,988,698,451.8
11	Санхүүгийн зардал	7,769,486,731.7	7,351,134,641.7
12	Бусад зардал	10,497,142,515.6	17,648,559,931.0
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	280,165.0	-4,482,390.0
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	0.0	0.0
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	0.0	0.0
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз ( гарз )	0.0	0.0
17	Бусад ашиг ( алдагдал )	0.0	0.0
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>-12,622,737,848.4</b>	<b>-9,642,037,844.2</b>
19	Орлогын татварын зардал	699,961,970.6	725,696,118.5
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>-13,322,699,819.0</b>	<b>-10,367,733,962.7</b>
21	<b>Зөгсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
22	<b>Тайланг үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>-13,322,699,819.0</b>	<b>-10,367,733,962.7</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	0.0	0.0
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.0	0.0
23.3	Бусад олз ( гарз )	0.0	0.0
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>-13,322,699,819.0</b>	<b>-10,367,733,962.7</b>
25	<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

№	Үзүүлэлт	Өмч	Энгийн хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хорвуулалт тийн нооц	Эднийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.0	287,684,089,300.0	420,000,000.0	41,284,046,791.0	0.0	1,905,957,879.0	-112,984,702,158.6	218,309,391,811.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-64,796,953.6	-64,796,953.6
3	Залруулсан үлдэгдэл	0.0	287,684,089,300.0	420,000,000.0	41,284,046,791.0	0.0	1,905,957,879.0	-113,049,499,112.3	218,244,594,857.7
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
5	Өмчид гаргасан өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
6	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
7	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-13,322,699,819.0	-13,322,699,819.0
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
9	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.0	287,684,089,300.0	420,000,000.0	41,284,046,791.0	0.0	1,905,957,879.0	-126,372,198,931.3	204,921,895,038.7
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-153,556,175.0	-153,556,175.0
11	Залруулсан үлдэгдэл	0.0	287,684,089,300.0	420,000,000.0	41,284,046,791.0	0.0	1,905,957,879.0	-126,525,755,106.3	204,768,338,863.7
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
13	Өмчид гаргасан өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0	605,818,953.7	0.0	605,818,953.7
14	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
15	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-10,367,733,962.7	-10,367,733,962.7
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
17	2020 оны 12-р сарын 31-ээрх	0.0	287,684,089,300.0	420,000,000.0	41,284,046,791.0	0.0	2,511,776,832.7	-136,563,238,738.8	195,336,674,184.9



## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант үеийн дүн	Өссөн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.0	0.0
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	62,678,173,141.2	62,678,173,141.2
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	61,749,453,014.5	61,749,453,014.5
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.0	0.0
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.0	0.0
1.1.4	Буцаан авсан албан татвар	85,870,562.4	85,870,562.4
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.0	0.0
1.1.6	Бусад мөнгөн орлого	842,849,564.3	842,849,564.3
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-62,336,387,271.3	-62,336,387,271.3
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-10,710,251,646.3	-10,710,251,646.3
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-2,206,110,868.7	-2,206,110,868.7
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-18,984,506,448.3	-18,984,506,448.3
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-11,647,188,032.8	-11,647,188,032.8
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд	-10,359,849,270.1	-10,359,849,270.1
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-4,602,816,490.7	-4,602,816,490.7
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-2,409,263,047.2	-2,409,263,047.2
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.0	0.0
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-1,416,401,467.2	-1,416,401,467.2
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	341,785,869.9	341,785,869.9
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.0	0.0
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.0	0.0
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	0.0	0.0
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	0.0	0.0
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	0.0	0.0
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	0.0	0.0
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан	0.0	0.0
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.0	0.0
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.0	0.0
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.0	0.0
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.0	0.0
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.0	0.0
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.0	0.0
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.0	0.0
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.0	0.0
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн	0.0	0.0
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.0	0.0
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,488,159,502.9	5,488,159,502.9
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	5,487,845,285.1	5,487,845,285.1
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас	0.0	0.0
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.0	0.0
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	314,217.7	314,217.7
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-5,674,051,809.1	-5,674,051,809.1
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-5,673,584,725.7	-5,673,584,725.7
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.0	0.0
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	0.0	0.0
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.0	0.0
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-467,083.4	-467,083.4
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-185,892,306.2	-185,892,306.2
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	155,893,563.7	155,893,563.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,681,304.5	7,681,304.5
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	163,574,868.2	163,574,868.2

## ТАТВАР ТӨЛӨЛТ

№	ТӨСӨВ БҮРДҮҮЛЭЛТ	ТАТВАРЫН ТӨРӨЛ	НИЙТ ДҮН
1	НДСанд	НДШ өглөг	4,151,874,729.95
2	Улсын төсөв	ОАТатвар	95,565,006.44
3		НӨАТ-ын өглөг	4,967,280,730.86
<b>ДҮН</b>			<b>9,214,720,467.25</b>
1	Орон нутгийн төсөв	АМНАТатварын өглөг	200,000,011.29
2		Тээврийн хэрэгслийн татвар	7,687,116.00
3		Газрын төлбөрийн өглөг	11,722,666.00
4		Ус ашигласны төлбөр	9,286,353.96
5		Үл хөдлөх хөрөнгийн татвар	413,649,456.42
6		Бусад татварын өглөг-Бууны	150,000.00
7		ХХОАТ-ын өглөг	1,792,943,276.26
<b>ДҮН</b>			<b>2,435,438,879.93</b>
<b>НИЙТ ДҮН</b>			<b>11,650,159,347.18</b>



## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



### АСАРВААНЬ ШООВДОР ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

МУ-н зөвлөх инженер, Аж үйлдвэрийн гавьяат ажилтан



### С.УРАНЧИМЭГ

Албан тушаал: Санхүү, эдийн засаг хариуцсан захирал  
Мэргэжил: Эдийн засагч, Мэргэшсэн нягтлан бодогч



### А.ДЭМЧИГЖАВ

Албан тушаал: Үйлдвэрлэл хариуцсан захирал  
Мэргэжил: Барилгын материал үйлдвэрлэлийн технологи инженер,  
Мэргэшсэн инженер



### Д.ВАЛЯХҮҮ

Албан тушаал: Техник хариуцсан орлогч  
Мэргэжил: Механик инженер, МУ-ын зөвлөх инженер,  
Аж үйлдвэрийн гавьяат ажилтан




### Х.МӨНХБААТАР

Албан тушаал: Технологи хариуцсан орлогч  
Мэргэжил: Барилгын материал үйлдвэрлэлийн технологи инженер,  
Мэргэшсэн шинженер

# УДИРДЛАГЫН БҮТЭЦ

## "Цемент Шохой" ХК-ийн удирдлагын бүтцийн схем



Утасны ажилтан 720  
Гэрээт ажилтан 15  
ИИИТ 735





## АЖИЛЛАХ ХҮЧ





## НИЙГМИЙН АСУУДАЛ

Шинэ төрлийн коронавирусийн дэгдэлт дэлхийн улс орнуудад хурдацтай тархсаны улмаас Монгол улсад тогтоосон цаг үеийн онцгой нөхцөл байдлын дэглэмийн дагуу жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Цагаан сар, Гавшгай хайрханы тахилга, ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах баяр, Наадам, Барилгачдын баяр, Ахмадын баяр, Шинэ жил гээд нийт 7 баяр ёслолын арга хэмжээг уг вирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс олон хүн цугларуулахгүйгээр зохион байгуулж, энэхүү арга хэмжээнд давхардсан тоогоор 3400 гаруй ажилчид, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн улмаас ажлаас гарсан ажилтнууд болон ахмадуудад гарын бэлэг гардуулж хүндэтгэл үзүүлсэн ба компанийн ажилтнуудад хөнгөлөлттэй үнээр 23,3 тонн гурил, 450,62 тонн нүүрс олгосон.



Мөн компанийн 2 ажилтны эмчилгээний 11,055,000 төгрөгийг хандивлалаа.

Мөн Сэлэнгэ аймаг Сайхан сумын хараа голын эрэг дагуу 6 га газарт 2700 ширэг бургас, хайлаас, улиас мод тарьсан ба компанийн байрнаас Хөтөл орох чиглэлийн 1,8 км бетонон хучилттай замыг сэргээн засварлаж, компанируу нэвтрэх явган хүний замыг халтиргаа гулгаанаас хамгаалалттай материалаар явган хүний хийж ажилтнуудынхаа эрүүл, аюулгүй байдлыг хангасан.

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Хөтөл хотын гэрэлт ирээдүй болсон хүүхэд багачуудын хөгжил дэвшил, сайн сайхныг дэмжих зорилгоор ажилтнуудын 717 хүүхдэд /18-аас доош насны/ Худалдаа Хөгжлийн банканд хадгаламжийн данс нээлгэж, данс түс бүрд мөнгө байршуулсан ба "Эрхээ мэдье" сэдэвт мэтгэлцээний улсын аварга шалгаруулах тэмцээнд Сайхан сумын ерөнхий боловсролын 1-р сургуулийн гурван багийн сурагчдыг ивээн тэтгэн оролцууллаа.

зардалд ажилчдаас хандив цуглуулсан





## НИЙГМИЙН АСУУДАЛ

Сайхан сумын хэмжээний зорилтот бүлгийн харьяалалтай амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой 7 ажилтныг нийгмийн хариуцлагын хүрээнд компанийн харьяалалдаа авч тусалж, дэмжиж ажилласаар байна. Эдгээр айл өрхүүдэд Цагаан сарын баяраар, мөн хүүхдүүдэд нь "ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-өөр тус тус гарын бэлэг гардуулж, 1 ажилтныг мэргэжлийн зэрэг нэмэгдүүлэх сургалтад компанийн зардлаар хамруулж, мэргэжлийн зэргийн үнэмлэх олгон дэмжлэг үзүүлсэн ба тус бүлэгт хамааралтай 200 гаруй өрх тус бүрд 25 кг гурил, Сэлэнгэ аймгийн Улаан загалмайн хорооны урсгал засварын ажилд зориулж 30 тонн цемент, Орхон сумын бүтээн байгуулалтад 20 тонн цемент, Чойжорпэлжайлин хийдийн урсгал засварт 7 тонн цемент, Баруунбүрэн сумын Засаг даргын тамгын газрын урсгал засварт 9 тонн цемент тус тус хандивлалаа.



Улс орон даяар гамшгаас хамгаалах "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг"-т шилжсэнтэй холбогдуулан Коронавирус /Covid-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар төр засаг, улсын Онцгой комиссоос гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ ард иргэдэд тусламж, дэмжлэг үзүүлж, Сайхан сумын онцгой комисс-д 5,000,000 төгрөг, "KN95" маск 500 ширхэгийг тус тус хандивласан ба сумын зорилтот бүлгийн 300 өрхөд 25 кг "Алтан тариа" ХХК-ийн Дээд гурил хандивласан.



## СУРГАЛТ ХӨГЖЛИЙН АЖИЛ

2020 онд үйлдвэрийн дэргэдэх сургалтын төвд 22 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 1764 ажилтныг хамруулан сургасан. Үүнд:

Компанийн дэргэдэх сургалтын төв нь мэргэжилтэй, үр чадвартай ажилтан бэлтгэх 3 төрлийн мэргэжлийн ангид 72 суралцагчийг сурган төгсгөж, Чадамжийн үнэлгээ, баталгаажуулалтын ажилтан бэлтгэх модуль-1,2 сургалтад компанийн 20 ИТА, мэргэжлийн багш нарыг сургаж, Үнэлгээний ажилтнаар бэлтгэсэн



Барилгын материалын технологич инженерийн мэргэшсэн зэрэг горилогчийн сургалтад-14, Зөвлөх инженерийн зэрэг сунгах сургалтад-2, Зөвлөх инженерийн зэрэг горилох сургалтад-1, Дулаан хангамж ашиглалтын инженерийн мэргэшсэн зэрэг горилогчийн сургалтад-1, Цахилгааны инженерийн мэргэшсэн зэрэг горилогчийн сургалтад-1, Механик инженерийн зэрэг горилогчийн сургалтад-3, Мэдээллийн системийн мэргэшсэн зэрэг горилогчийн сургалтад-1, нийт 23 удирдлага, ИТАжилтнууд Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн сургалтад хамрагдан амжилттай төгссөн.

Мөн "Дархан-Өргөө" ПТК-ийн Сантехникийн техникчийн ангид компанийн 5 ажилтан суралцан дипломын боловсрол эзэмшиж, мэдлэг үр чадвараа дээшлүүлсэн.



Олон жил үр бүтээлтэй ажилласан, ажлын дадлага туршлагатай ажилтны мэдлэг үр чадварыг бусад ажилтнуудад эзэмшүүлэх, залгамж халааг бэлтгэх зорилгоор багш шавийн гэрээгээр 2 ажилтныг ажлын байран дээр дагалдуулан суралцуулсан зэрэг ажилтнуудыг хөгжүүлэх чиглэлийг голлон анхаарч ажилласан болно.



## БИДНИЙ ОЛОЛТ АМЖИЛТ

Монгол улсын хөгжил дэвшил, бүтээн байгуулалтад оруулж буй компанийн хувь нэмрийг үнэлж:

- Монгол Улсын шилдэг бүтээгдэхүүнээр шалгаруулан “Үлэмжийн чанарын батламж”-аар 3 удаа;
- “Монгол улсын шилдэг аж ахуйн нэгж TOP-100”-д 6 удаа, TOP-150-д 4 удаа;
- “Монгол улсын барилгын материалын үйлдвэрлэлийн шилдэг аж ахуйн нэгж, байгууллагаар 4 удаа;
- Шилдэг үндэсний үйлдвэрлэгч”-ээр 3 удаа;
- МҮХАҮТ-ын “INTREPRENEUR 2011” шалгаруулалтаас “Монгол улсын үндэсний үйлдвэрлэлийг тэргүүлэгч оны онцлох Энтрепрейнер”;
- “BARILGA AWARDS” -аас “Барилгын материал үйлдвэрлэгч шилдэг байгууллага”-аар 4 удаа
- БХБЯ, МБХ-ийн шилдэг төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байгууллагаар;
- Үндэсний шилдэг бүтээн байгуулалтын “Bloomberg awards” шагнал;
- Аж үйлдвэрийн яам” -ны тэргүүн дээд шагнал “Билэгт гөрөөс”;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд шагнал “Алтан гадас” одон;
- “Үндэсний бүтээн байгуулалтын дээд шагнал - ТӨРИЙН ГЭРЭГЭ” зэрэг шагналуудыг хүртсэн.





- Хөтөл Дархан-Уул 56 км
- Хөтөл Эрдэнэт 127 км
- Хөтөл Улаанбаатар 275 км
- Төвийн бүсэд төмөр болон засмал зам дагуу байрласан.
- Бүтээгдэхүүнээ машин, вагонд савтай, задгайгаар ачих боломжтой.



khutulcement.mn



khutulcement



info@khutulcement.mn



70368368, 70368151